

Уул уурхайн сайдын 201... оны ... сарын ...-ны

өдрийн .. дугаар тушаалын хавсралт

## **“Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага”**

Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг хайгуулын хугацаанд хийгдсэн геологи, геофизик, геохими болон гидрогеологийн хайгуул судалгаа, өрөмдлөг, туршилт, үнэлгээ, олборлолтын туршилт, лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэн бичнэ. Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайлан нь дор дурдсан агуулгатай байна.

### **Нэг. Газрын тосны ордын тухай ерөнхий мэдээлэл**

Энэ бүлэгт ордын засаг захиргааны харъяалал, газар зүйн байршил, газрын тосны геологийн судалгааны товч түүх, бүс нутгийн дэд бүтэц, эдийн засгийн хөгжлийн төлөв байдал, ордын нийт талбай, нөөц бодсон блокуудын тоо, хэмжээ, дугаар, нөөцийн хэмжээ, олборлолтын түүх зэрэг ерөнхий мэдээллийг тусгана.

### **Хоёр. Газрын тосны ордын геологийн тогтоц**

Энэ бүлэгт газрын тосны ордын талбайн хэмжээнд тархсан чулуулгийн давхарга зүйн ангилал, насны үндэслэл, тунамал хурдсын геологи-структурын онцлог, ашигт давхаргадас, газрын тосны орд, хураагуурын бүтэц тогтоц, хураагуурын төрөл, хураагуурын петрофизикийн онцлог, тос үүсгэгч болон агуулагч чулуулгийн шинж чанар зэргийг бичсэн байна. Давхарга зүйн ангилалд Монгол улсын стратиграфийн кондексыг баримтлана.

### **Гурав. Газрын тосны хайгуул судалгаа, олборлолтын ажлууд**

Энэ бүлэгт газрын тосны хайгуулын хугацаанд хийж гүйцэтгэсэн геологи, геофизик, өрөмдлөг, дээжлэлт, лабораторын шинжилгээ, үнэлгээ, олборлолтын туршилт болон судалгааны бусад ажлын төрөл, аргачлал, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй тусгаж, хайгуул судалгааны ажлын тоо хэмжээ, баталгаажсан зардлыг хайгуулын жил тус бүрээр тооцож гаргана.

### **Дөрөв. Ордын гидрогеологийн нөхцөл**

Энэ бүлэгт талбайн гидрогеологийн хайгуулын ажлын үр дүн (гедрогелогийн нөхцөл, бие даасан уст үе, давхарга, цооногийн шавхалт, туршилт, усны найрлага, химийн шинж чанар, гүний усны нөөцийн хэмжээ болон бусад шаардлагатай үзүүлэлтүүд)-гийн талаар тодорхой тусгасан байна.

### **Тав. Газрын тосны нөөцийн тооцоо, ангилал, үнэлгээ**

Дэлхийн газрын тосны хороо (WPC), Дэлхийн газрын тосны инженерүүдийн нийгэмлэг (SPE), Америкийн газрын тосны геологийн холбоо (AAPG), Газрын тосны инженерүүдийн үнэлгээний нийгэмлэг (SPEE)-ээс хамтран боловсруулж, газрын тосны инженерүүдийн нийгэмлэг (SPE)-ээс баталсан газрын тосны нөөц, баялгийн

менежментийн систем (Petroleum Resources Management System, 2007)-ийн дагуу газрын тосны баялаг, нөөц, тосонд ууссан хийн нөөцийг баталгаат (proved), магадтай (probable), боломжит (possible), зэрэглэлээр тооцоолсон байна.

Энэ бүлэгт газрын тосны нөөцийн ангилал ба зэрэглэл, тэдгээрийн тодорхойлолт, нөөцийн тооцоонд хэрэглэсэн арга, нөөцийн тооцооны үзүүлэлтүүд (сүвшилт, нэвчимж, капиллярын сүвийн даралт, фазын нэвчимж, сүвшил дэх усны ундрага, тосны нягт, тос-усны зааг, тостой давхаргын эзлэхүүний коэффициент, тостой үеийн ашигт зузаан гэх мэт) –ийг тогтоосон үндэслэл, нөөцийн тооцоолол, нөөцийн үнэлгээ, үр дүнгийн талаар бичихдээ газрын тосны инженерүүдийн нийгэмлэг (SPE)-ээс баталсан газрын тосны нөөц, баялгийн менежментийн систем (Petroleum Resources Management System, 2007)-ийг баримтална.

Ордын хайгуул, үнэлгээ, олборлолтын ажлын үр дүнгээр нөөцийн тооцоо хийхэд шаардлагатай хураагуурын горим, ан цавын зүй тогтол, шингэний урсгал, нөөцийн талбайн хил, тос-усны зааг, тосны доод хязгаар болон бусад үзүүлэлтүүдийг нарийвчилан тогтоож баталсан байна.

Нөөцийг блок, ашигт давхаргадас (oil formation), ашигт зузаалаг (pay zone), тус бүрээр тооцно. Тосыг баррель/тонн, тосонд ууссан хийг куб метрээр илэрхийлнэ. Нөөцийн блокууд, ашигт давхаргадас, ашигт зузаалгуудыг дэс дараатай, ойлгомжтой дугаарласан байна. Нөөцийн тооцооны үзүүлэлт, үр дүнг нэгдсэн хүснэгтэнд оруулна.

#### **Тайлангийн хавсралт зураг, тооцооны хүснэгт, бусад материалууд:**

- Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн байршилын зураг
- Ордын хайгуул, үнэлгээний ажил гүйцэтгэсэн талбай, шугам, цооногийн байршил зэргийг харуулсан зураг /масштаб 1:25,000/
- Ордын геологи-тектоникийн зураг /масштаб 1:25,000/
- Ордын геологи-структурын зураг, зүсэлтийн хамт /масштаб 1:10,000-1:25,000/
- Хураагуурын дээд ба доод гадаргуугийн гүний тогтоцын зургууд, цооногийн байршилын хамт /масштаб 1:10,000-1:25,000/
- Нөөцийн блокуудын зургууд, цооногийн байршил, цооногоор огтолсон тост үеийн тоо, ундарга, зузаан болон зүсэлтийн шугамын хамт /масштаб 1:10,000-1:50,000/
- Нөөцийн блокуудын геологийн зүсэлт /босоо ба хэмтээ масштабыг бичсэн байх/
- Чичирхийллийн судалгааны тайлал хийсэн зүсэлт /босоо ба хэвтээ масштабыг бичсэн байх/
- Хурдас чулуулгийн фац, тос агуулсан элсэн чулууны тархалт, зузаан түүний сүвшилтийн тархалт, ашигтай зүвшилтийн зургууд, цооногийн байршилын хамт /масштаб 1:10,000/
- Нөөцийн блокуудын цооногийн геологи- геофизикийн нэгдсэн зүсэлт
- Бусад шаардлагатай зургууд.

Ордын нөөцийн тооцоонд ашигласан цооногийн чөмөг чулуун ба хананаас авсан дээжийн жагсаалт, дээжилсэн гүн, дээжийн лабораторийн

шинжилгээний төрөл, үр дүн, цооногуудын жагсаалт, координатын хамт, цооногт хийсэн туршилт, үнэлгээ (перфораци, шингэн хагалбар гэх мэт)-ийн ажлууд, олборлолтын түүх болон олборлолт, тос өгөмжийг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэсэн ажлууд, олборлолтын туршилтын ажлын үр дүн зэргийг хавсаргана.

-oOo-